



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар Б/25

Улаанбаатар хот

Т.Батболдыг албан тушаалд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2, Хан-Уул дүүргийн Усан спорт, сургалтын төв орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.1 дэх заалт, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 05/5549 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тунгалагийн Батболдыг Хан-Уул дүүргийн Усан спорт, сургалтын төв орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлаар 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс томилсугай.

2.Т.Батболдын ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ч.Базарзаяа	Засаг даргын орлогч
Гишүүд:	Ч.Ариунжаргал	Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Г.Одонгоо	Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	М.Ариунжаргал	Дүүргийн архивч
Нарийн бичиг:	Г.Однаран	Төрийн албан хаагчийн ёс зүй, сургалт хариуцсан мэргэжилтэн

3.Т.Батболдын үүрэгт ажлыг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан хүлээлцэхийг ажлын хэсэг (Ч.Базарзаяа)-т, албан тушаалын нэг сарын үндсэн цалинг (ТҮ-9), 1,630,000 (нэг сая зургаан зуун гучин мянган) төгрөгөөр тогтоож, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний нэмэгдлийг нэг сарын үндсэн цалингийн 40 хувиар тооцож сар бүр олгохыг Хан-Уул дүүргийн Усан спорт, сургалтын төв орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газрын нягтлан бодогч Г.Нацагдоржид тус тус даалгасугай.

4.Т.Батболдтой хариуцлагын гэрээ байгуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Ч.Мөнхгэрэл)-т, байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Ч.Ариунжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭН

1725010332